



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 67,900,000.00 (жаран долоон сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 48,700,000.00 (дөчин найман сая долоон зуун мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Ц.Ганчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000870


 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
 газрын 2019 оны 10 дугаар сарын 29 -ны
 431 дүний тогтоолын хавсралт

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжээс хөгжлийн
 бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын балансад шилжүүлэх үлдэх өртөггүй хөрөнгийн цаашид ашиглах
 хугацаа, нийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Тоёото Хайс маркийн, 56-10 УНУ улсын дугаартай, JTF5X22P606145462 арлын дугаартай суудлын автомашин	2014/2014	1	67,900,000.00	67,900,000.00	48,700,000.00	19,200,000.00
			1		67,900,000.00	48,700,000.00	19,200,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)		67,900,000.00 (жаран долоон сая есөн зуун мянга)	48,700,000.00 (дөчин найман сая долоон зуун мянга)	19,200,000.00 (арван есөн сая хоёр зуун мянга)